



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/192

Булган сум

“Сансар марафон 2024” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хүн сансарт ниссэний 43 жилийн ой, Булганчуудын бахархлын өдрийг тохиолдуулан гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор “Сансар марафон 2024” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:


Ажлын хэсгийн ахлагч: Д.Жаргалсайхан (Аймгийн Засаг даргын орлогч дарга)
Гишүүд: Г.Алтанцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)
Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
Г.Ганбаяр (Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа)
Ш.Баасандорж (Онцгой байдлын газрын дарга, хурандаа)
П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)
П.Нөхөрлөлбаяр (Булган сумын Засаг дарга)
О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)
В.Батболд (Хөнгөн атлетикийн холбооны тэргүүн)
Нарийн бичгийн дарга: Ё.Хулан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээнд зарцуулагдах 12,800,000 (арван хоёр сая найман зуун мянга) төгрөгийг “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх төлөвлөгөө”-ний төсөл хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

4.Тэмцээний зохион байгуулалт, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсэг (Д.Жаргалсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/192 дугаар
 захирамжийн хавсралт

“Сансар марафон 2024” арга хэмжээний төсөв

Д/д	Тэмцээний төрөл	1-р байр	2-р байр	3-р байр	4-р байр	5-р байр	Дүн
1	2	3	4	5	6	7	8
1	21 км эр 18-45 нас	500,000	300,000	200,000	100,000	80,000	1,180,000
2	21 км эм 18-45 нас	500,000	300,000	200,000	100,000	80,000	1,180,000
3	21 км эр 46 дээш нас	300,000	200,000	150,000	100,000	80,000	1,180,000
4	21 км эм 46 дээш нас	300,000	200,000	150,000	100,000	80,000	1,180,000
5	5000 м 18-34 эр	150,000	120,000	100,000	80,000	60,000	510,000
6	5000 м 18-34 эм	150,000	120,000	100,000	80,000	60,000	510,000
7	5000 м 13-17 эр	100,000	80,000	60,000	40,000	30,000	310,000
8	5000 м 13-17 эм	100,000	80,000	60,000	40,000	30,000	310,000
9	3000 м 35-49 эр	150,000	120,000	100,000	60,000	50,000	480,000
10	3000 м 35-49 эм	150,000	120,000	100,000	60,000	50,000	480,000
11	2000 м 50-аас дээш	150,000	120,000	100,000	60,000	50,000	480,000
12	2000 м 50-аас дээш	150,000	120,000	100,000	50,000	30,000	480,000
13	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмэгтэй 2000 м15-аас дээш нас	150,000	120,000	100,000	50,000	30,000	450,000
14	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмэгтэй 2000 м15-аас дээш нас	150,000	120,000	100,000	50,000	30,000	450,000
15	1000 м 8-12 эм	100,000	80,000	60,000	40,000	20,000	300,000
16	1000 м 8-12 эр	100,000	80,000	60,000	40,000	20,000	300,000
Нийт				9,780,000			
Бусад зардал							
Д/д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Нийт зардал		
1	2	3	4	5	6		
1	Медаль	100	ш	30,200	3,020,000		
Нийт дүн				12,800,000			